

“УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ”

Нээлттэй хэлэлцүүлэг



**УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦЛИЙГ САНАЛ БОЛГОХ НЬ:
ХӨГЖИЛД ХҮРГЭХ БОДЛОГЫН ЖОР**

ИЛТГЭЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Н.Баяртсайхан, Д.Ган-Очир 2017, 'Эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгох бодлогын асуудалд', *Мөнгө, Санхүү, Баялаг сэтгүүл*, 2017/02 [2], хуудас 4-30.



АГУУЛГА

1 Удиртгал

Тогтвортой өсөлт, хөгжлийг хангах бодлогын жор
яагаад чухал вэ?



2 Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс

Өсөлтийн эмпирик баримт
Өсөлтийн барагцаалсан болон гүнзгий тодорхойлогчид



3 Өсөлт, хөгжилд чиглэсэн бодлогын жор

Бодлогын жорын түүхэн хувьсал
Дэлхийн банкны өсөлт, хөгжлийн хорооны зөвлөмж



4 “Улаанбаатарын зөвшилцөл”-ийн төсөл

Цаашид анхаарах асуудлууд
Улаанбаатарын зөвшилцлийг санал болгох нь




- Эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг хангаж чадсанаар эдийн засгийн хөгжлийн суурь бүрдэж, ядуурлын түвшин буурдаг.
 - Эдийн засгийн урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох
 - Мэдлэгт тулгуурласан, олон тулгууртай эдийн засгийн бүтцийг бий болгох (П.Жасрай 2007, Н.Баяртсайхан 2014)
- Монголын эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх бодлогын жор юу вэ?
 - Уул уурхайн салбараас орж ирэх орлогод суурилан уул уурхайн бус, өөрийн орны онцлог давуу талд суурилсан салбарыг хөгжүүлэн эдийн засгийг төрөлжүүлж, тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох
 - Хөгжлийн эдийн засгийн онол, бусад орнуудын туршлага, өөрийн орны онцлог
- Энэхүү илтгэлээр Монгол улсыг тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх “Улаанбаатарын зөвшилцөл (Ulaanbaatar Consensus)”-ийн төслийг санал болгож байна.
 - Улс төрийн орчноос үл хамааран Монгол төрийн хөгжлийн бодлогод тусч хэрэгжиж байх





Зураг 1. МУ-ын эдийн засгийн өсөлт, хувиар



Эх сурвалж: ҮСХ

1991-2016 оны жилийн дундаж **өсөлт 4.4 хувь** байна.

- Арифметик дундаж нь 4.6 хувь
- Геометр дундаж нь 4.9 хувь
- Стандарт хазайлт нь 6.1 хувь

Өсөлт **хэт өндөр хэлбэлзэлтэй**, гадаад шокоос хэт их хамааралтай байна.

- Өрхийн зээл нэмэгдэх нөхцөл болж байна.
- Ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулах зэрэг нийгмийн зорилтыг хангах боломжийг хязгаарлаж байна.

Тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох:

- Гадаад шокоос дархлаатай эдийн засаг
- Ажлын байр олноор бий болгох эдийн засгийн бүтэц: олон тулгууртай болгох
- Хөдөлмөрийн бүтээмж нэмэгдүүлэх

- Хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт нь тогтворгүй, хэлбэлзэл өндөртэй:
 - Хаана шинэ санаа гарч, бүтээмж өндөр байна тухайн улс илүү өндөр өсөлттэй байснаар орлогын ялгаа нэмэгдсэн
- Эдийн засгийн өсөлтийн бага түвшний ялгаа нь амьжиргааны маш том ялгааг бий болгодог:
 - 1820-1992 оны хооронд жилийн дундаж өсөлт баруун Европт 2.2 хувь, АНУ-д 3.6 хувь, Ази тивд 1.9 хувь, Африк тивд 1.9 хувь (Maddison 2001).
 - Өсөлт хоорондын зөрүү нь бага хэдий ч, урт хугацаанд нөлөө нь хуримтлагдсаар эдгээр улс орнуудын орлогын ялгааг цаг хугацааны туршид эрс нэмэгдүүлсэн.



Удиртгал



Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс




Өсөлт, хөгжилд чиглэсэн бодлогын жор



“Улаанбаатарын зөвшилцөл”-ийн төсөл

Зураг 2. Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс



Эх сурвалж: Rodrick (2003)

- Газар зүйн байршил:
 - Байгалийн баялгийн их, бага байх
 - Хөрсний чанар, хур тунадас
 - Цаг уур -> эрүүл мэнд-> хүмүүн капитал
 - Тээврийн зардал-> Худалдаа -> зах зээлийн интеграци
 - Колончлол-> институци <- байгалийн баялаг
- Худалдаа:
 - Гадаад худалдаа нь эдийн засгийн конвергенцид чухал үүрэгтэй (Sachs & Warner 1995)
 - ОУ-ын байгууллагууд: худалдааны интеграцид орох
 - Шинэ өсөлтийн онол: Технологийн дам нөлөө, суралцах нөлөө, менежмент, ГШХО
- Институци:
 - Өмчийн эрх, төрийн зохистой бүтэц (check & balance), шүүхийн бие даасан байдал, төрийн чадавхи
 - Өсөлт <-> институци сайжирдаг
- Өсөлт, худалдаа, институци:
 - Өсөлт -> Худалдаа, институци
 - Институци -> гадаад худалдаа

Манай орны хувьд газар зүйн байршил:

- Байгалийн баялаг
- Далайд гарцгүй, гэхдээ 2 том гүрний дунд
- Эрс тэрс цаг агаар, гэхдээ мал аж ахуй эрхлэх боломжтой


Гадаад худалдаа:

- Уул уурхайн экспорт, гэхдээ тогтвортой бус
- Технологийн болон суралцах нөлөө харьцангуй удаан
- ГШХО нь уул уурхайн салбарт төвлөрсөн

Институци:

- Байгалийн баялаг -> Засаглал, институци сул: “Баялагийн хараал”
- Өсөлт нь тогтворгүй-> иргэдийн амьжиргаа доогуур -> сул институци

 **Зураг 3. Улс төрийн болон эдийн засгийн институци хувьсал**




Эх сурвалж: Acemoglu and Robinson (2008)

Улс төрийн хүртээмжтэй институци

- Иргэдийн оролцоог хангах (олноор хэлэлцэж шийдвэр гаргах)
- Хууль ёсыг дээдлэх: хариуцлага, хяналтын тогтолцоо
- Улс төрчдийн үйл хөдлөлийг хууль ёсны хүрээнд хязгаарлах

 **Зураг 4. Улс үндэстнийн доройтлын шалтгааны динамик**



Эх сурвалж: Acemoglu (2011)

Эдийн засгийн хүртээмжтэй институци

- Хүн амын дийлэнх хэсгийн өмчийн эрхийг хамгаалах (жишээ нь, жижиг аж ахуй, үйлдвэрлэл эрхлэгч)
- Хуулийг мөрдөх
- Шинээр бизнес эрхлэгч зах зээлд харьцангуй чөлөөтэй нэвтрэх
- Зах зээлүүд дэх төрийн дэмжлэг (нийгмийн бараа хангах, зохицуулалт болон гэрээний хэрэгжилт хангуулах)
- Ард иргэдийн дийлэнх хэсэгт боловсрол авах, бусад боломжид хамрагдах тэгш эрх олгох

1960-1970 он

Засгийн газрын
хэт оролцоо нь
саад учруулдаг

1980-1990 он



Хөгжил буурай орнуудад төрийн оролцоог чухалчилж байв:

- “Чөтгөрийн тойрог”: бага орлого -> бага хуримтлал -> бага хөрөнгө оруулалт-> бага орлого гэсэн циклийг таслах
- Төлбөрийн тэнцлийн алдагдал, хөрөнгө оруулалтын сангийн дутагдлыг зээл, тусламжаар нөхөх
- Маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийх
- Стратегийн ач холбогдолтой салбарт л хөрөнгө оруулалт хийх

Жон Виллиамсон нарын “Вашингтоны зөвшилцөл”

- Эдийн засгийн өсөлт доогуур байсан: газрын тосны хямралын дараа Латин Америкийн ихэнх орнууд өрийн хямралд орсон.
- Бодлогын зөвлөмж нь зах зээлийг хөгжүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, чөлөөт худалдаа хийх зэрэгт төвлөрч байв.
- АНУ-ын Засгийн газар, Дэлхийн Банк, ОУВС: Латин Америкийн орнуудад хэрэгжүүлэх

Анхны Вашингтоны зөвшилцөл (Williamson 1989)

1. Төсвийн сахилга батыг хангах
2. Төсвийн зардлыг боловсрол, эмнэлэгийн үйлчилгээ, дэд бүтцэд чиглүүлэх
3. Татварын шинэчлэл хийх: өсөн нэмэгдэх татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх
4. Санхүүгийн либералчлал
5. Эдийн засгийн өрсөлдөх чадварыг хангахуйц валютын ханштай байх
6. Гадаад худалдааг либералчлах
7. Гадаадын хөрөнгө оруулалтын дотогшлох урсгалыг чөлөөтэй болгох
8. Улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах
9. Захиргаадалтын шинж чанартай төрийн зохицуулалтыг халах
10. Өмчийн эрхийн эрх зүйн баталгааг бүрдүүлэх

Сайжруулсан Вашингтоны зөвшилцөл: нэмэлт 10 зарчим (Rodrick 2006)

11. Компанийн засаглал сайжруулах
12. Авлигалын эсрэг тэмцэх
13. Хөдөлмөрийн уян хатан зах зээлийг бий болгох
14. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болох
15. Санхүүгийн код, стандартчиллыг бий болгох
16. Зохистой түвшинд хөрөнгийн зах зээлийг нээх
17. Валютын ханшийн дундын дэглэм баримтлахгүй байх
18. Бие даасан төв банк/инфляцийг онилох
19. Нийгмийн асуудалд анхаарлаа хандуулах
20. Ядуурлын түвшинг бууруулах



Удиртгал

Эдийн засгийн өсөлтөд
нөлөөлөгч хүчин зүйлсӨсөлт, хөгжилд чиглэсэн
бодлогын жор“Улаанбаатарын
зөвшилцөл”-ийн төсөл

1990-2000 он

**Вашингтоны зөвшилцөл шүүмжлэлд өртсөн:**

- Хөгжиж буй орнуудын нэг хүнд ногдох орлогын медиан өсөлт 1960-1979 онд 2.5 хувь байсан бол 1980-1998 онд 0 хувь болсон: Алдагдсан 20 жил (Easterly 2001)
- “Нэг хэмжээ бүгдэд таарахгүй”: Латин Америкийн орнуудад тохироогүй- улс орны өөрийн онцлогт тохирох ёстой (Хятад, Энэтхэг)
- Засгийн газрын хэт бага эсвэл хэт өндөр оролцооны аль аль нь сөрөг нөлөөтэй.
- Гол шүүмжлэгчид нь Stiglitz (1998) болон Rodrick (2002, 2003)
- 1990-ээд оны сүүлээс шинэ (эндоген) өсөлтийн онол гарч ирсэн: институци, тухайн орны онцлогт тулгуурласан шинэчлэл

2000 он-

**Шинэ зөвшилцлийн эрэлд гарсан:**

- Дэлхийн банкны Ерөнхийлөгч Wolfensohn 2004 он: Вашингтоны зөвшилцөл нас нөхцөөд олон жил болсон
- Нэр дэвшигчид: Шинэ Вашингтоны зөвшилцөл (Kuczynski & Williamson 2003), Сайжруулсан Вашингтоны зөвшилцөл (Rodrick 2006), Барселоны зөвшилцөл (Blanchard болон бусад 2004), Бээжингийн зөвшилцөл (Joshua 2004), Бээжин-Сөүл-Токиогийн зөвшилцөл (Lee & Matthews 2011), Дэлхийн банкны өсөлт, хөгжлийн хорооны зөвшилцөл (Commission on Growth and Development 2008).

**Тогтвортой өсөлтийн жор
(Stiglitz 1998)**

- Бодит эдийн засаг, инфляцийг тогтворжуулах
- Либералчлал нь санхүүгийн салбарын зохицуулалтыг сайжруулна
- Өрсөлдөөний бодлоготой байх
- Засгийн газрын үүргийг хязгаарлахаас илүүтэй үр ашгийг нэмэгдүүлэх
- Хүмүүн капиталыг сайжруулах
- Хөгжиж буй орнуудад технологийн дэвшлийг нэвтрүүлэх

**Шинэ Вашингтоны зөвшилцөл
(Kuczynski & Williamson 2003)**

- Төсвийн сахилга бат дангаар хүрэлцээтэй бус: Хямралаас зайлсхийх
- Либералчлал, хувьчлалыг дуусгах
- Институцийг сайжруулах
- Үндэсний инновацийн тогтолцоо бий болгох
- Шүүх, төрийн үйлчилгээ, өмчийн эрх, улс төрийн шинэчлэлийг хийх
- Ядуу иргэдийн хөрөнгө орлогыг боловсрол, бичил зээл, газрын шинэчлэлээр дамжуулан нэмэгдүүлэх



Удиртгал

Эдийн засгийн өсөлтөд
нөлөөлөгч хүчин зүйлсӨсөлт, хөгжилд чиглэсэн
бодлогын жор“Улаанбаатарын
зөвшилцөл”-ийн төсөл

Барселоны зөвшилцөл**(Blanchard, Calvo, Fischer зэрэг академик эдийн засагчид 2004)**

- Хөгжлийн стратеги- чанартай институци, гэхдээ бүү хуулбарла
- Улсын өр хэт өсөх, банкны зохицуулалт сул байх, мөнгөний хэт зөөлөн бодлого хэрэгжүүлэх нь эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөөтэй.
- Экспорт, аж үйлдвэржилтийг дэмжих, технологийн инноваци, мэдлэгийг эзэмших: ялангуяа өсөлтийг боомилж буй хязгаарлалтуудыг арилгах
- Олон талт худалдааны хэлцлүүд хөгжлийг дэмждэг
- Хүн амын улс хоорондын шилжих хөдөлгөөнийг дэмжих
- Байгаль орчны асуудал, тухайлбал дэлхийн дулаарлын эсрэг арга хэмжээ авах

Бээжин-Сөүл-Токиогийн зөвшилцөл**(Lee & Matthews 2011)**

- Өрсөлдөх чадвартай компаниуд байгуулж, тэдний чадавхийг бүрдүүлэх
- Аж үйлдвэржилтэд замчлах төрийн агентлагийг байгуулж, үйл ажиллагааг нь дэмжих
- Компаниудад ахисан түвшний мэдлэг, мэдээлэл авахад нь туслаж, дэмжлэг үзүүлэх
- Зах зээлээ тэлэхийн тулд экспортын салбарыг дэмжих
- Хөгжилд чухал үүрэг гүйцэтгэх (эхэндээ импортыг орлох) салбар, технологийг дэмжих
- Бүх шатны боловсролыг хөгжүүлэх
- Гадаад хамтын ажиллагаатай, гэхдээ санхүүгийн хувьд хэт либералчлагдаагүй санхүүгийн тогтолцоог бий болгох
- Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах
- Зах зээлийн бус төрийн интервенциэс алгуур татгалзах

Бээжингийн зөвшилцөл**(Joshua 2004)**

- Эдийн засгийн өсөлтөнд хүрэх явц: гол гарахын тулд чулуу бүр дээр үсэрч гарах ёстой
- Инноваци, дэлхийн түвшний технологийг ашиглах нь өсөлтөд чухал нөлөөтэй
- Өсөлт чухал хэдий ч, байгаль орчны асуудал, орлогын тэгш бус байдлыг байнга харгалзах шаардлагатай



Удиртгал



Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс



Өсөлт, хөгжилд чиглэсэн бодлогын жор



“Улаанбаатарын зөвшилцөл”-ийн төсөл

Дэлхийн банкны өсөлт, хөгжлийн хорооны зөвлөмж (2008)

- 2006 оны хавар анх байгуулагдаж 2010 оны 6 сард ажлаа дууссан.
- 2 Нобелийн шагналт эдийн засагч, хурдацтай хөгжиж буй орнуудын лидерүүдээс бүрдсэн.

<ul style="list-style-type: none"> • Их хэмжээний хөрөнгө оруулалт хийх: Хөрөнгө оруулалтын задаргаа чухал-> дэд бүтэц (хувийн хөрөнгө оруулалт татах), хүмүүн капитал 	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн салбарыг хөгжүүлэх: санхүүгийн зах зээл эрийн цээнд хүрсэн үед л зах зээлээ нээх нь зүйтэй.
<ul style="list-style-type: none"> • Шинэ мэдлэг, технологийг хурдан авч ашиглах: ГШХО & гадаадад боловсол эзэмших 	<ul style="list-style-type: none"> • Хотжилт, орон нутгийн дэд бүтцийг өргөтгөх чиглэлд хөрөнгө оруулалт хийх
<ul style="list-style-type: none"> • Өрсөлдөөн, бүтцийн өөрчлөлтийг дэмжих: Schumpeter-ийн “үр бүтээлтэй сүйтгэл”, бүтээмжийн өсөлтийг бий болгох 	<ul style="list-style-type: none"> • Боломжийн тэгш эрхээр хангах: Дахин хуваарилалтын механизмыг боловсронгуй болгох
<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр нэг байгууллага дотор, салбар хооронд чөлөөтэй шилждэг байх: шинэ чадвар эзэмших, шинэ ажил эрхлэх боломжийг олгох 	<ul style="list-style-type: none"> • Бүс нутгийн хөгжилд анхаарах: боломжийн дахин хуваарилалтыг хийж, тэгш хөгжих нөхцлийг бүрдүүлэх
<ul style="list-style-type: none"> • Экспортыг дэмжих аж үйлдвэржилтийн бодлого: ЗГ-ын түр зуурын дэмжлэг, үр дүнг үнэлэх, салбаруудад ижил тэгш хандах 	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчныг хамгаалах, эрчим хүчний ашиглалтыг сайжруулах
<ul style="list-style-type: none"> • Валютын ханшийн тухайн орны өрсөлдөх чадварыг хангах түвшинд байлгах: экспортыг дэмжих, хөрөнгийн огцом орох урсгал экспортын салбарт сөрөг нөлөөлөхөөс хамгаалах 	<ul style="list-style-type: none"> • Үр ашигтай засгийн газрыг бий болгох: төрийн албан хаагчийн чадавхи, бүтээмж өндөр байх, авлигатай шийдэмгий, ил тод тэмцэх
<ul style="list-style-type: none"> • Хөрөнгийн урсгал, санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал: нээлттэй болгох цаг хугацаа, үе шат-> санхүүгийн хувьд нээлттэй болоход төрөлжилт, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг харгалзана. 	<ul style="list-style-type: none"> • Хэлэлцүүлэг, мэтгэлцээний чанарыг дээшлүүлэх (Тинк-Танк): муу бодлогыг зогсоох, сайн бодлогыг хэрэгжүүлэх
<ul style="list-style-type: none"> • Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах: Төв банкны хараат бус байдал, төв банк өсөлтийг харгалзах, засгийн өр/ДНБ-ий харьцаа 	<ul style="list-style-type: none"> • ОУ-ын туршлагаар батлагдсан буруу бодлогыг давтан хэрэгжүүлэхгүй байх
<ul style="list-style-type: none"> • Дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх: Чөтгөрийн тойргийг таслах 	



Удиртгал



Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс



Өсөлт, хөгжилд чиглэсэн бодлогын жор



“Улаанбаатарын зөвшилцөл”-ийн төсөл

- ✓ Засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх, авлигалын эсрэг тууштай тэмцэх,
- ✓ Дэлхий ертөнц бүхэлдээ шинэ хөрөнгө оруулалтын төлөөх тулааны талбар болсон энэ үед гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах,
- ✓ Төсвийн сахилгыг хангах, үндэсний хуримтлалтай болж, тууштай нэмэгдүүлэх, бодит эдийн засаг, инфляцийг тогтворжуулах,
- ✓ Эдийн засгийн дархлааг хангах хэмжээнд гадаад валютын нөөцийг хуримтлуулах, өрийн дарамтад орохоос сэргийлэх,
- ✓ Хүчтэй санхүүгийн салбартай болох, санхүүгийн зах зээлийг зохистой төвшинд либералчлах, өрсөлдөөн бий болгох,
- ✓ Аж үйлдвэржилтэд түүчээлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай зүтгүүр хэдэн компанийг бий болгож дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх
- ✓ Дэлхийн болон бүс нутгийн дэд бүтцийн том хөтөлбөрүүдэд багтаж орох, газар нутгийн байршлын давуу талаа ашиглах, аймаг, орон нутгууд тэгш хөгжих боломж бүрдүүлэх,
- ✓ Байгалийн баялагаа оновчтой байдлаар эдийн засгийн эргэлтэнд оруулах, “Баялагийн ерөөл”-д хүргэх, хүртээмжтэй өсөлтийг бий болгох

